



**АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2017 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/206

Улаанбаатар хот.

**“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын
ажилтны “Мэргэжил, ур чадварын түвшин тогтоох журам”
батлах тухай**

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 55 дугаар тогтоолоор баталсан “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын дүрмийн 6.10.6, 6.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын ажилтны “Мэргэжил, ур чадварын түвшин тогтоох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын ажилтны “Мэргэжил, ур чадварын түвшин тогтоох журам”-ыг 2017 оны 06 дугаар сарын 12-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Энэхүү тушаалыг нийт ажилтнуудад танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, сургалт, хүний нөөцийн хэлтэс /Г.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4. Тушаал гарсантай холбогдуулан “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын захирлын “Мэргэжил, ур чадварын түвшин тогтоох журам” батлах тухай 2015 оны 10 дугаар сарын 06-ны А/217 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



П.ДЭЛГЭРНАРАН



БАРИМТЖУУЛСАН ЖУРАМ
СҮАЖ – ЗСХНХ -04-2017

Автотээврийн үндэсний төвийн
захирлын 2017 оны 06 сарын 06 өдрийн
1206 дугаар тушаалын хавсралт



“АЖИЛТНЫ МЭРГЭЖИЛ, УР ЧАДВАРЫН ТҮВШИН ТОГТООХ ЖУРАМ”

Боловсруулсан	Хянасан
	
Д.Энхбат	Н.Зориг

ЭХ ХУВЬ

МӨРДӨЖ ЭХЛЭСЭН ОГНОО: 2015.10.06

ӨӨРЧЛӨЛТИЙН ОГНОО: 2017.06.12

ӨӨРЧЛӨЛТИЙН № 01

ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Д/д	Өөрчлөлт №	Хуудас №	Өөрчлөлтийн утга

Баримт бичгийн № СҮАЖ - ЗСХНХ - 04 -2017	"Ажилтны мэргэжил, ур чадварын түвшин тогтоох журам"	
Хэвлэсэн огноо: 2017.--	Өөрчлөлт № 00	Хуудас № 2/ 13
	Өөрчлөлтийн огноо: 2017.03.28	

Өмнөх үг

Мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хувийн хэвшил давамгайлсан эдийн засгийн тогтвортой хөгжилд шаардагдах мэргэжил, хүн хүчний хэрэгцээгээ төлөвлөх, таамаглах, ажиллах хүчээ бүрдүүлэх, давтан сургаж, тасралтгүй хөгжүүлэх, мэргэжлийн боловсрол, чадварлаг ажилчидыг дэмжих шаардлага бий болсон.

Ажилтанд тавигдаж буй орчин үеийн шаардлагыг мэргэжил мэргэшлийн түвшин бүрээр боловсруулж гаргах нь ажил олгогчдын гол үүргийн нэг болж байна. Зах зээлийн өндөр хөгжилтэй улс орнуудад хүний нөөцийг хөгжүүлэх, үүний дотор мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаас сургалтын хөтөлбөр боловсруулахад ашиглахын тулд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг дэлгэрэнгүй тайлбарлан мэргэжил мэргэшлийн чадварыг тодорхойлон бичсэн баримт бичгийг боловсруулдаг болжээ. Энэхүү нөхцөл байдалд уяалдуулан "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ хөгжлийн стратеги, хүний нөөцийн бодлоготой уялдуулан ажилтны мэдлэг, ур чадварын түвшинг тогтоох тодорхойлох, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, хөгжүүлэх, шалгалт авах, дүн гаргах, удирдах зэргээр үйл ажиллагаандаа хэрэглэнэ.

Баримт бичгийн № СҮАЖ - ЗСХНХ - 04 -2017	"Ажилтны мэргэжил, ур чадварын түвшин тогтоох журам"	
Хэвлэсэн огноо: 2017.---	Өөрчлөлт № 00	Хуудас № 3/13
	Өөрчлөлтийн огноо: 2017.03.28	

АГУУЛГА

д/д	Бүлэг	Хуудас №
	Өөрчлөлтийн бүртгэл	2
	Өмнөх үг	3
	Агуулга	4
1	Зорилго	5
2	Хамрах хүрээ	5
3	Баримт бичгийн хариуцагч	5
4	Норматив баримт	5
5	Нэр томъёоны тодорхойлолт	6
6	Үйл явцын диаграмм	7
7	Ерөнхий шаардлага	8
8	Үр дүнгийн шалгуур	11
9	Хариуцлага	11
11	Үйл явцын бүртгэл	14
12	Хавсралт	15

Баримт бичгийн №
СҮАЖ - ЗСХНХ - 04 -2017

"Ажилтны мэргэжил, үр чадварын түвшин тогтоох журам"

Хэвлэсэн огноо: 2017.--.--

Өөрчлөлт № 00

Өөрчлөлтийн огноо: 2017.--.--

Хуудас № 4/ 13

НЭГ. ЗОРИЛГО

1.1. Энэхүү журмын зорилго нь “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ (цаашид “Үйлдвэрийн газар” гэх) –ийн хөгжлийн стратеги, хүний нөөцийн бодлоготой уялдуулан ажилтны мэдлэг, ур чадварын түвшинг тогтоох, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, хөгжүүлэх, удирдахад оршино.

1.2. Ажилтны мэргэжил, ур чадварын түвшин тогтоох нь ажилтны мэдлэг, ур чадварыг үнэлэх гол шалгуур болно.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1. Энэ журам нь үйлдвэрийн газрын ажилтнуудын мэргэжил, ур чадварын түвшин тодорхойлох шалгалт авах, дүн гаргах, үр дүнг тайлагнах үйл явцад хамаарна.

ГУРАВ. БАРИМТ БИЧГИЙН ХАРИУЦАГЧ

3.1. Ажилтны мэргэжил, ур чадварын түвшинг тогтоох аргазүй, удирдлага, зохион байгуулалтыг хангах ажлыг “Мэргэжил, ур чадварын түвшин тогтоох” комисс /цаашид комисс гэх/ хариуцна.

ДӨРӨВ. НОРМАТИВ БАРИМТ БИЧГИЙН ИШ ТАТАЛТ

4.1. Энэхүү журам нь олон улс болон Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дараах стандарт, эрх зүйн баримт бичгийн холбогдох шаардлага, заалтыг үндэслэн боловсруулсан болно. Үүнд:

- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар
- MNS ISO 9000 - 2001 Чанарын удирдлагын тогтолцоо --- Суурь асуудал, тайлбар толь
- MNS ISO 9001 - 2016 Чанарын менежментийн тогтолцоо—Шаардлага
- MNS ISO/TR 10013: 2001. Чанарын удирдлагын тогтолцооны баримт бичигт зориулсан заавар
- MNS 5140-1 - 2011 Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичиг. 1-р хэсэг: Баримт бичгийн нэр, төрөл, тодорхойлолт
- MNS 5140-2 - 2011 Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичиг. 2-р хэсэг: Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлага
- MNS 5140-3 - 2011 :Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичиг. 3-р хэсэг: Баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэдгээрт бүрдлүүдийг байрлуулахад тавих шаардлага

Баримт бичгийн № СҮАЖ - ЗСХНХ - 04 -2017	"Ажилтны мэргэжил, ур чадварын түвшин тогтоох журам"	
Хэвлэсэн огноо: 2017.---	Өөрчлөлт № 00	Хуудас № 5/ 13
	Өөрчлөлтийн огноо: 2017.---	

ТАВ. БАРИМТ БИЧГИЙН НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ , ТОВЧИЛСОН
ҮГИЙН ТАЙЛАЛ


5.1. Журмын хүрээнд дараах нэр томьёонуудыг ашиглана:

“Үйлдвэрийн газар” – Автотээврийн үндэсний төв /ТӨҮГ/

“Үйл явцын диаграмм” - Дотоод зохион байгуулалтын нэгжүүдийн хүрээнд дангаар болон хамтран хэрэгжүүлэх тодорхой гарц бүхий үйл явцыг зураглан дүрсэлсэн баримт бичиг .

Баримт бичгийн № СҮАЖ - ЗСХНХ - 04 -2017	“Ажилтны мэргэжил, ур чадварын түвшин тогтоох журам”	
Хэвлэсэн огноо: 2017.--	Өөрчлөлт № 00	Хуудас № 6/ 13
	Өөрчлөлтийн огноо: 2017.--	

ЗУРГАА. ҮЙЛ ЯВЦЫН ДИАГРАММ



Баримт бичгийн № СҮАЖ - ЗСХНХ - 04 - 2017	"Ажилтны мэргэжил, ур чадварын түвшин тогтоох журам"	
Хэвлэсэн өгнөө: 2017.--	Өөрчлөлт № 00	Хуудас № // 13
	Өөрчлөлтийн өгнөө: 2017.--	

ДОЛОО. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

7.1. Ажилтны мэргэжил, ур чадварын түвшин тогтоох шалгалтыг авахад дараах зарчимийг баримтална.

7.1.1. Шалгалтын үйл ажиллагаа хараат бус, шударга, байх

7.1.2. Шалгуулагч этгээдэд адил тэгш хандаж, түүний хууль ёсны эрх, ашиг сонирхол, нэр төрийг хүндэтгэн харилцах;

7.1.3. Шалгалтын сорил нь хоёрдмол ойлголтгүй, тодорхой байх

7.1.4. Төлөвлөгөөт бус шалгалтыг авахдаа тухайн ажилтны үйл ажиллагааны эрсдэлийг үнэлсэн дотоод хяналт, шинжилгээний дүнг үндэслэх;

7.2. Ажилтны мэргэжил, ур чадварын түвшин тогтоох ажлын зохион байгуулалт

7.2.1. Ажилтны мэргэжил, ур чадварын түвшинг тогтоох аргазүй, удирдлага, зохион байгуулалтыг хангах ажлыг "Мэргэжил, ур чадварын түвшин тогтоох" комисс /цаашид комисс гэх/ хариуцна.

7.2.2. Ажилтны мэргэжлийн ур чадварын түвшинг тогтоох комиссын бүрэлдэхүүнд үйлдвэрийн газрын дадлага, туршлага бүхий ахлах мэргэжилтэн ба түүнээс дээш албан тушаалын 3-5 албан хаагчийг томилно. Комиссын дарга, нарийн бичгийн дарга, гишүүд гэсэн бүрэлдхүүнтэй байна. Комиссыг үйлдвэрийн газрын захирлын тушаалаар батална.

7.2.3. Комисс нь батлагдсан удирдамжийн дагуу ажиллана. Мэргэжил, ур чадварын түвшинг дараах хэлбэрээр тогтооно.

а) Төлөвлөгөөт (Үйлдвэрийн газрын орон тооны ажилтнууд);

б) Төлөвлөгөөт бус (Захирлын зөвлөлийн хуралдааны шийдвэр, ажилтан албан тушаал дэвших, өөрийн болон ажил олгогчийн хүсэлтээр хамрагдах ажилтнууд).

7.2.4. Комисс нь батлагдсан удирдамжийн дагуу ажиллана. Мэргэжил, ур чадварын түвшинг дараах хэлбэрээр тогтооно.

7.2.5. Туршилтын хугацаагаар ажиллаж байгаа ажилтныг үндсэн ажилтнаар томилохдоо "Мэргэжил, ур чадварын түвшин тогтоох журам"-ын дагуу шалгалтанд хамруулана.

7.2.6. Мэргэжил, ур чадварын түвшинг тогтоох явц; гаргасан шийдвэрийн талаар комиссын нарийн бичгийн дарга протокол хөтөлж баримтжуулна.

Баримт бичгийн № СҮАЖ - ЗСХНХ - 04 - 2017	"Ажилтны мэргэжил, ур чадварын түвшин тогтоох журам"	
Хэвлэсэн огноо: 2017.---	Өөрчлөлт № 00	Хуудас № 8/ 13
	Өөрчлөлтийн огноо: 2017.---	

ᠮᠤᠨᠤᠯᠤᠰ
ᠰᠤᠶ᠋ᠠᠵᠤ - ᠵᠢᠰᠬᠠᠨᠬᠤ
ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠭ

7.3. Ажилтны мэргэжил, ур чадвар тогтоох дэг

7.3.1. Комисс нь мэргэжил, ур чадварын түвшинг тогтоох ажлын удирдамжийг хамрагдах ажилтануудад ажлын 10 хоногийн өмнө урьдчилан танилцуулсан байна.

7.3.2. Ажилтны мэргэжлийн ур чадварын түвшин тогтоох бэлтгэл ажлыг бүрэн хангасан байна. Үүнд:

- а) Ажилтанд мэргэжил, ур чадварын түвшин тогтоох тухай мэдээлэлийг урьдчилан өгч, сургалтанд хамруулах;
- б) Мэргэжил, ур чадварын түвшинг тогтоох үнэлгээний хуудсыг ажилтан өөрөө болон шууд удирдах албан тушаалтан бөглөж комисст ирүүлэх /Хавсралт 1/.

7.3.3. Комисс нь ажилтны мэргэжлийн ур чадварын түвшинг шалгаж, үнэлгээ өгч, шийдвэр гарган баталгаажуулна.

7.3.4. Мэргэжил, ур чадварын түвшин тогтооход тухайн ажилтан хүндэтгэх шалтгаангүйгээр ирээгүй тохиолдолд комисс зохих шийдвэр гаргана.

7.4. Үнэлгээ, шалгуур үзүүлэлт

7.4.1. Ажилтны мэргэжил, ур чадварын түвшин тогтоох төрөл:

7.4.1.1. Ерөнхий мэдлэг шалгалт- 30 асуулт /тестээр/

7.4.1.2. Мэргэжилийн онолын мэдлэгийн шалгалт -30 асуулт /тестээр/

7.4.1.3. Ярилцлага болон албан баримт, бичиг боловсруулалт

7.4.2. Мэргэжил, ур чадварын түвшинг тогтооходоо дараах шалгуур үзүүлэлтийг ашиглана. Үүнд:

7.4.2.1. Ерөнхий мэдлэгийн шалгалтын асуултыг 70 ба түүнээс дээш хувь зөв хариулсан тохиолдолд Мэргэжилийн онолын мэдлэгийн шалгалтыг авна.

7.4.2.2. Ерөнхий мэдлэгийн шалгалтын асуултыг 70-аас доош хувь хариулсан тохиолдолд Мэргэжилийн онолын мэдлэгийн шалгалт өгөх эрхгүй бөгөөд тэнцээгүй үнэлгээ авна.

7.4.2.3. Мэргэжилийн онолын мэдлэгийн шалгалтын асуултыг 70 ба түүнээс дээш хувь зөв хариулсан бол ярилцлагын шалгалтанд орно.

7.4.2.4. Мэргэжилийн онолын мэдлэгийн шалгалтын асуултыг 70-аас доош хувь хариулсан тохиолдолд ярилцлагын шалгалтад орох эрхгүй бөгөөд тэнцээгүй үнэлгээ авна.

7.4.2.5. Ярилцлага болон албан баримт, бичиг боловсруулалтаар 65 ба түүнээс дээш хувийн үнэлгээ авсан тохиолдолд шалгалтанд тэнцсэн үнэлгээ авна.

7.4.2.6. Ярилцлага болон албан баримт, бичиг боловсруулалтын асуултыг 65-аас доош хувь хариулсан тохиолдолд тэнцэхгүй үнэлгээ авна.

Баримт бичгийн № СҮАЖ - ЗСХНХ - 04 -2017	"Ажилтны мэргэжил, ур чадварын түвшин тогтоох журам"	
Хэвлэсэн огноо: 2017.--	Өөрчлөлт № 00	Хуудас № 9/ 13
	Өөрчлөлтийн огноо: 2017.--	

7.5. Үр дүнг тооцох

7.5.1. Комисс ажилтны мэргэжил, ур чадварын түвшинд дор дурдсан үнэлгээг өгнө. Үүнд:

№	Хувь	Үнэлгээ	Тайлбар
1	85-100	"бүрэн хангалттай"	Албан тушаал дэвшүүлэх ажилтны нөөцөд бүртгэх
2	65-85	"хангалттай"	Мэргэжил, ур чадварын хувьд одоо гүйцэтгэж байгаа ажил албан тушаалдаа тэнцэнэ
3	65-аас бага	"Хангалтгүй"	Хөдөлмөрийн гэрээг цуцлах

7.5.2. Комисс нь ажилтны мэргэжил, ур чадварын түвшин тогтоосон нэгдсэн дүнг Захиргааны асуудал хариуцсан нэгжид өгч, дэлгэрэнгүй тайланг захиралд танилцуулна.

7.5.3. Ажилтны мэргэжил, ур чадварын түвшингээс хамаарч сургалтын нэгдсэн төлөвлөгөөг захиргааны асуудал хариуцсан нэгж боловсруулж, хэрэгжүүлнэ.

7.6. Бусад

7.6.1. Ажилтны мэргэжил, ур чадварын түвшинг тогтоосон шийдвэр болон холбогдох материалыг архивын нэгж болгон архивт хадгалагдана.

7.6.2. Ажилтны мэргэжил, ур чадварын түвшин тогтоох ажил нь шинээр ажилд орсон, үндсэн ажилтнаар томилогдох, албан тушаал дэвших ажилтнуудын хүрээнд жилд нэг удаа, Үйлдвэрийн газрын хэмжээнд 2 жил тутамд нэг удаа зохион байгуулагдана.

7.6.3. Ажилтны мэргэжил, ур чадварын түвшин тогтооход дараах ажилтнууд үл хамаарна. Үүнд:

- хүүхэд асрах чөлөөтэй байгаа ажилтан
- контрактын гэрээгээр ажиллаж буй ажилтнууд
- гэрээгээр ажиллаж буй иргэд

7.6.4. Тухайн ажилтны мэргэжил, ур чадварын түвшин тогтоолтын дүн нь нууцын зэрэглэлтэй байна.

7.6.5. Шалгалтаар хангалтгүй дүн үзүүлсэн нь ажилтныг Хөдөлмөрийн тухай хууль болон Хөдөлмөрийн дотоод журамд заасанаар ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл болох бөгөөд тушаалд тодорхой тусгана.

Баримт бичгийн № СҮАЖ - ЗСХНХ - 04 - 2017	"Ажилтны мэргэжил, ур чадварын түвшин тогтоох журам"	
Хэвлэсэн огноо: 2017.---	Өөрчлөлт № 00	Хуудас № 10/13
	Өөрчлөлтийн огноо: 2017.---	

7.6.6. Комиссын гаргасан шалгалтын дүнг захиргааны ямар нэг байгууллага, албан тушаалтан авч хэлэлцэн өөрчлөх эрхгүй.

324

НАЙМ. ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР

8.1. Үр дүнгийн шалгуурт дараах үзүүлэлтүүд орно.

- 8.1.1. Аж ахуйн нэгж, иргэдээс үйлдвэрийн газарт ирсэн өргөдөл, гомдолын тоо;
- 8.1.2. Үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд ажилтны буруугаас үүсэх үл тохирлын тоо;
- 8.1.3. Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар төлөвлөгөөт хугацаандаа биелэгдсэн байдал;
- 8.1.4. Онол, арга зүйн төвшин;
- 8.1.5. Хууль тогтоомжид нийцсэн байдал;
- 8.1.6. Хэрэглэгчдийн үнэлгээ;

ЕС. ХАРИУЦЛАГА

1.1. Энэхүү журмын хүрээнд албан тушаалтан дараах үүргийг хүлээнэ.

Албан тушаал	Чиг үүрэг
Дээд удирдлага	Мэргэжил, ур чадварын түвшин тогтоох комиссийг томилох, бүрэн хангалттай үнэлгээ авсан ажилтныг албан тушаал дэвшүүлэх,
Мэргэжил, ур чадварын түвшин тогтоох комисс	Мэргэжил, ур чадварын түвшинг тогтоох бэлтгэл ажлын удирдамж болон шалгалтын тест боловсруулах, шалгалтын тов зарлах; Мэргэжил, ур чадварын түвшинг тогтоох шалгалтын тестийг олшруулах, баталгаажуулах, битүүмжлэх ажлыг шалгалтын комиссын нарийн бичгийн дарга хариуцах ба нууцлалыг чандлан хадгалах.
	Ажилтнуудын мэргэжил, ур чадварын түвшинг тогтоох шалгалтыг журмын дагуу авах, мэргэжлийн түвшинг тодорхойлох; Мэргэжил, ур чадварын түвшинг тогтоосон дүнг гаргах, тайланг танилцуулж дүнгийн үзүүлэлтийг харгалзан ажилтаныг дэвшүүлэх, сургалтанд хамруулах саналыг захиралд танилцуулах;
	Мэргэжил, ур чадварын түвшинг тогтоох ажлыг цаашид хэрхэн сайжруулж, боловсронгуй болгох талаар санал гаргах;

Баримт бичгийн № СҮАЖ - ЗСХНХ - 04 -2017	"Ажилтны мэргэжил, ур чадварын түвшин тогтоох журам"	
Хэвлэсэн огноо: 2017.---	Өөрчлөлт № 00	Хуудас № 11/13
	Өөрчлөлтийн огноо: 2017.---	

Захиргааны асуудал хариуцсан нэгж	<p>Ажилтнуудын ур чадварын түвшин тогтоох ажлыг удирдан чиглүүлэх;</p> <p>Комисст арга зүйн зөвлөгөө өгөх;</p> <p>“Мэргэжил, ур чадварын түвшин тогтоох” комисстой хамтран ур чадварын түвшин тогтоох шалгалтын тестийг албан тушаалын онцлогийг харгалзан боловсруулах;</p> <p>Мэргэжил, ур чадварын түвшинг тогтоох шалгалтанд хамрагдах ажилтнуудын судалгааг тухай бүр гаргаж нэрсийг комисст өгөх;</p> <p>Мэргэжил ур чадварын түвшинг тогтоосон комиссын шийдвэр, холбогдох материалыг ажилтны хувийн хэрэгт хадгалах;</p> <p>Мэргэжил, ур чадварын түвшинг байнга сайжруулж байх зорилгоор ажилтнуудыг сургалтанд хамруулж байх;</p> <p>Мэргэжил, ур чадварын түвшингээс хамаарч сургалтын хэрэгцээг тодорхойлох, хэрэгцээнд нийцсэн сургалтын төлөвлөгөө боловсруулах.</p>
Нэгжийн дарга нар	Хариуцсан нэгжийн ажилтны мэргэжил, ур чадварын түвшинг тогтоох үнэлгээний хуудсыг бөглөж комисст ирүүлэх
Албан хаагчид	<p>Ажилтны мэргэжлийн ур чадварын түвшин тогтоох шалгалтад бэлтгэсэн байна.</p> <p>Мэргэжил, ур чадварын түвшинг тогтоох үнэлгээний хуудсыг бөглөж комисст ирүүлэх.</p> <p>Мэргэжил, ур чадварын түвшин тогтоох шалгалтад идвэхитэй оролцох.</p>

Баримт бичгийн №	“Ажилтны мэргэжил, ур чадварын түвшин тогтоох журам”	
СҮАЖ - ЗСХНХ - 04 - 2017		
Хэвлэсэн огноо: 2017.--.--	Өөрчлөлт № 00	Хуудас № 12/ 13
	Өөрчлөлтийн огноо: 2017.--.--	

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын
Ажилтны мэргэжил, ур чадварын түвшин
тогтоох журмын 1-р хавсралт

МЭРГЭЖИЛ, УР ЧАДВАРЫН ТҮВШИН ТОГТООХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

1	Овог нэр:	
2	Төрсөн он:	
3	Мэргэжил, боловсролын түвшин:	
4	Боловсролын болон эрдмийн зэрэг, цол:	
5	Ажилласан хугацаа:	
6	Эрхэлж байгаа албан тушаал	
7	Ерөнхий мэдлэг /хувь/	
8	Мэргэжлийн ур чадвар/ хувь/	
9	Ярилцлага /хувь/	
10	Нийт /хувь/	
11	Шалгалтын үнэлгээ:	
12	Шалгалтын комиссын шийдвэр	
13	Шалгалтын дүгнэлттэй танилцсан ажилтан/...../ /гарын үсэг/ /нэр/

Шалгалт авсан комиссын дарга: / /

Гишүүд: / /

..... / /

..... / /

..... / /